

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

| | | | |
|---|-----------------------|---------------------|-----------|
| Ярилцлага өгөгчийн нэр | Дамбажамц | Дугаар | L112 |
| Оршин суугаа аймаг | Хэнтий | Оршин суугаа сум | Хэрлэн |
| Төрсөн газар | Өндөрхаан хот | Төрсөн он | |
| Ажил мэргэжил | Өндөр настан | | |
| Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд | Гүндгаварлин хийд | Сүм хийдийн дугаар | ХЭӨХ059 |
| Одоогийн сүм хийд | Гүндгаварлин хийд | Сүм хийдийн дугаар | ХЭӨХ 063 |
| Ярилцлага авсан он сар өдөр | 2007 оны 6-р сарын 18 | Ярилцлага авсан хүн | Ж.Одгарьд |



Хэнтий аймгийн Хэрлэн сумын Гүндгаварлин хийд

-Гүндгаварлин хийдийн талаар ярилцлага авъя аа? Шинэ хийд маань хэдэн онд сэргээгдсэн гээд энэ тухай? 1660 онд байгуулагдсан. Анхны чойртой байгуулагдаж байсан. Гучин хэдэн онд хаагдсан. Бүх л дацангууд байсан. Гол дуганыг нь 1953 онд нураасан. Маршал Чойбалсан 1949 онд дайнд явахдаа битгий нураагаарай гэсэн. Дараа нь хэлсэн үг нь буруудаад дээр нь мод буулгаад барилга барьсан. Шүтээн энэ тэр нь музей энэ тэрд байдаг байх. Яг 1938 онд хаагдсан. Манай багш лам хурлаа хураад хаасан. 1990 оноос хурлыг нь таслаагүй. Сарын дүйчин өдрүүдэд хурлаа хурдаг байсан. Цогчин хурал хурна. 1990-6-1-нд сэргээн байгуулагдсан. 80-аад лам нар байсан. 1992 онд энэ дуганыг барьсан.

-Энэ хийд өөрөөр нэрлэгддэг байсан уу?

Цагаан эргийн хийд гэдэг байсан.

-Хэн гэдэг хүн санаачилж байгуулсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Шолой сэцэн хаан.

-Танайханд өөрсдөд чинь бичсэн юм байгаа юу?

Юм бий. Би өөрийн сонссон ерөнхий л юмаа л ярьж байна.

-Хэдэн лам хурдаг байсан юм бол?

1000 гаран ламтай байсан. Хужиртын хүрээ бас нэг 1000 гаран ламтай байсан гэсэн. Энд тэндээс ч лам нар ирж хурдаг байсан.

-Хийдийн хутагт хувилгаадын талаар? Ном судар бичдэг байсан болов уу?

Манайд бол Өндөрхааны судар байдаг. Хувилгаан хутагт байсан. 13 тамгатай хутагтууд, 80 гаруй хувилгаанууд байдаг. Хувилгаан багшийн зураг нь байдаг. Нутгийн улсуудад янз бүрийн зүйлс байхыг үгүйсгэх аргагүй. Сайн мэдэхгүй байна.

-Зурхайч эмч нар?

Байсан байх. Тэрбиш зурхайчийн багш Жамба гэдэг хүн байдаг байсан.

Дуганыг ямар материалаар барьсан бэ?

Дуганаа модоор барьсан байсан.

-Яг хэдэн дуган байсан юм бол оо?

Тэр тоог нь би сайн мэдэхгүй. Манай аав бага байхдаа тахилч байсан. Ер нь дацан болгон үүдэндээ цогчинтой байсан. Хүрээндээ эмэгтэй хүн орохгүй. Лам нарынх нь байр байдаг байсан. Тэндээ жинхэнэ эрдэм номоо хөөдөг байсан гэсэн.

-Хийдэд өөрийн бар гэж бий юу?

Үгүй байгаагүй байхаа. Манай энд нэг сонин хоолтой. Лонгуу гэж хоол бий. Мах, саахар, будаа, ус үзэм, давс, шар тос ордог.

-Ямар ямар ном барлаж хэвлэж байв?

-Хуучин хүрээг байгуулаад хамгийн сүүлд энийг байгуулсан юм гэнэ лээ гэх юм байна уу?

Материаллаг бааз, сүрах нөхцөл их байсан. Сайн сайн лам байсан. Манай багш бол Дамбадаржаа гээд аргагүй сайн лам байсан. -Хурал номуудын талаар? Сарын хурал?

Тэрийг сайн мэдэхгүй. Намар нэг хангал гэж хурдаг байсан. 29-нд хуучин хурлаа хурна.